# ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
# 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтод түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 1: Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | | |
| **1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2-т заасан Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.** | | | | | | | | |
| 1.1.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | -Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь. | Лавлагаа шатлалын ЭМБайгууллагууда д танхимаар 2 удаа, цахимаар 2 удаа Анхан шатны ЭМБайгууллагууда д танхимаар 2 удаа, цахимаар-2 удаа зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулсан. | 1 | 1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад 12-3 сарыг хамруулж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 1 удаа дүн шинжилгээ хийн ажилласан байна. Үүнд: Программ ашигалалттай холбоотойгоор анхан шатны материал илгээгээгүй, код ахиулах, анхан шатны материалын бичилт дутуу, иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний чанар хангалтгүй, зэрэг алдаа дутагдлууд нийтлэг байна. Мөн амбулаторын үзлэгийг яаралтай тусламжаар бүртгэж, завших оролдлого хийсэн байж болзошгүй байдал илрүүлсэн. Дүн шинжилгээний мөрөөр 1 удаа анхан шатны эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж хүргүүлсэн ба зарим эрүүл мэндин байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхээр төлөвлөж байна. | 100 |
| 1.1.2 | Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023, 2024 оны статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | ЭМДЕГ-аас гаргасан 4, ЭМДХ-ээс бэлдсэн 2 статистик мэдээллийг байгууллагын пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. | 1 | 1 | 2023, 2024 оны өөрийн хэлтсийн статистик мэдээллийг боловсруулан 60 гэрээт эрүүл мэндийн байгуулагад илтгэл мэдээлэл хэлбэрээр 1 удаа хүргүүлэн ажилласан. Пэйж хуудас хаагдсан тул Өмнөговь аймгийн төрийн байгууллагын бичиг хэргийн дотоод И-оффис мэдээллийн системд байдаг 57 байгууллагын мэдээллийн самбарт байршуулж, санхүүгийн мэдээтэй хамт Нийгмийн бодлогын хэлтэс, Төрийн сангийн хэлтсүүдэд хүргүүлж, байгууллагын ил тодын самбарт байршуулан ажиллаа.Нийт 118 байгууллагад статистик мэдээлэл хүргэсэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3 | “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн шинэчлэн батлагдсан тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо<br>- Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04, 11 дугаар тогтоолыг гэрээт 20 эрүүл мэндийн байгууллагад танилцуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. | 20 | 20 | ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04, 11-р тогтоолыг 59 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, тогтоолд гарсан өөрчлөлтийн мэдээллийг илтгэл мэдээлэл хэлбэрээр 1 удаа хүргүүлсэн байна. Мөн ЭМДҮЗ-ийн тогтоолын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр танхимын сургалтыг 1 удаа, эрүүл мэндийн салбарын удирдлагуудын мэдээллийн цаг уулзалтад 2 удаа мэдээлэл өгч ажилласан байна. Тогтоолын хэрэгжилтийг хангах, хяналттай холбоотойгоор зохион байгуулсан цахим хурлуудын зарыг эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр хүргэж байна. | 100 |
| 1.1.4 | “ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах” тухай ЭМДҮЗ-ийн шинэчлэн батлагдсан тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | - | -Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо<br>-Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ 2025 оны 05 дугаар тогтоолыг гэрээ бүхий 17 анхан шатны ЭМБ-д хүргэн мэдээллээр хангаж ажиллаа. | Тухай бүр | Тухай бүр | ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04, 11-р тогтоолыг 59 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, тогтоолд гарсан өөрчлөлтийн мэдээллийг илтгэл мэдээлэл хэлбэрээр 1 удаа хүргүүлсэн байна. Мөн ЭМДҮЗ-ийн тогтоолын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр танхимын сургалтыг 1 удаа, эрүүл мэндийн салбарын удирдлагуудын мэдээллийн цаг уулзалтад 2 удаа мэдээлэл өгч ажилласан байна. Тогтоолын хэрэгжилтийг хангах, хяналттай холбоотойгоор зохион байгуулсан цахим хурлуудын зарыг эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр хүргэж байна. | 100 |
| 1.1.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | - | -Санхүүжүүлсэн мөнгөн дүн<br>-Хамрагдсан даатгуулагчийн тоо | ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, 2024 онд 2697 иргэн хамрагдаж 451,521,000 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | 1348<br>2257 60.5 төг | 1349<br>225,760,5 төг | 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж гүйцэтгэл ирүүлсэн БОЭТ-ийн 712 даатгуулагчийн 125,660,000 төгрөгийн нэхэмжлэлийг хүлээн авч 704 даатгуулагчдад 120,895,000 төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон байна. Мөн Лавлагаа шатлалын хувийн эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр эрт илрүүлэг зохион байгуулах, гэрээ байгуулах арга зүйн зөвлөмжийг 1 байгууллагад өгч ажилласан. | 70 |
| 1.1.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, | - | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн | - | 1 | 1 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж хүргүүлэх | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | | газарт хүргүүлсэн саналын тоо | | | | ажлын хүрээнд ЭМДЕГ-аас ирүүлсэн төсөлд дотоод албан бичгээр 2 удаа санал хүргүүлсэн.<br><br>Мөн эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний гүйцэтгэлд чанар төлбөрийн хяналтаар илрүүлсэн алдаа, газар дээрх хяналтаар илрүүлсэн зөрчил зэргийг нэгтгэн 6 дугаар сарын 05-ны дотор хүргүүлэхээр бэлтгэж байна. Учир нь Газар дээрх хяналтын хугацаа сунгагдаж, хуулийн байгууллагад шилжүүлэх ноцтой завших оролдлогууд илэрч, эцсийн байдлаар хохиролын дүн бүрэн гараагүй байна. | |
| 1.1.7 | "ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо<br>-Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна. | Тухай бүр | Тухай бүр | ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04, 11-р тогтоолыг 60 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, тогтоолд гарсан өөрчлөлтийн мэдээллийг илтгэл мэдээлэл хэлбэрээр 1 удаа хүргүүлсэн байна. Мөн ЭМДҮЗ-ийн тогтоолын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр танхимын сургалтыг 1 удаа, эрүүл мэндийн салбарын удирдлагуудын мэдээллийн цаг уулзалтад 2 удаа мэдээлэл өгч ажилласан байна. Тогтоолын хэрэгжилтийг хангах, хянахтай холбоотойгоор зохион байгуулсан цахим хурлуудын зарыг эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр хүргэж байна. | 100 |
| **1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд:** | | | | | | | | |
| 1.2.1 | *Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.1.3, БГТ-1.4.3*<br>Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | -Хүргүүлсэн саналын тоо | Эрүүл мэндийн даатгалын бодлогын бичиг баримтад 2 удаа санал хүргүүлсэн. | Тухай бүр | Тухай бүр | Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгөх ажлын хүрээнд: 1. Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмын төсөл болон<br>2. Эрүүл мэндийн даатгалын орлогын шимтгэлийг бүрдүүлэх, төвлөрүүлэх журамд санал хүргүүлсэн байна. | 100 |
| 1.2.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын | - | Зөрчлийн хэргийн тоо | 2024 онд Прокурорын байгууллагатай хамтран 13 иргэний ЭМДС-ийн зардлыг тогтоон шүүхэд 26,800,000 | 1 | 1 | Эхний хагас жилийн байдлаар зөрчлийн хэргийн дугаар 1 удаа авсан ба хуулийн байгууллагад шилжүүлэх, шалгалтын танилцуулга, дүгнэлт бичигдэх ажил хийгдэж байна. Шүүхэд 7 иргэний 30,887,386 төгрөгийн нэхэмжлэл гаргасан бол Цагдаагийн байгууллагад 5 иргэний нэхэмжлэгчээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагатай хамтран ажиллана. | | | төгрөгийн нэхэмжлэл гаргасан. | | | 26,858,489 төгрөгийг гаргуулахаар албан хүсэлтээ өгсөн байна. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ЭМДсангийн мөнгөн хөрөнгийг байршуулах Төрийн сан банкны дугаарыг хүргүүлэн, улирал бүр мэдээлэл авч хамтран ажиллах албан тоотыг хүргүүллээ. | |
| **2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | | |
| **2.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан "Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ" зорилтын хүрээнд:** | | | | | | | | |
| 2.1.1 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7. БГТ 2.1.1* Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 50.0 | 25% | 25% | 2025 онд 2,258 малчин ЭМД хамрагдахаар төлөвлөсөн ба 2025 оны 05 сарын 27-ны өдрийн байдлаар 937 малчин хамрагдаж 114,505,460 төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 83 хувьтай байна. | 85,2 |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 100 | 50% | 50% | 2025 онд 1,671 оюутан ЭМД хамрагдахаар төлөвлөсөн ба 2025 оны 05 сарын 27-ны өдрийн байдлаар 2041 оюутан хамрагдаж 166,412,120 төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 100 хувьтай байна. | |
| | | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 55 | 30% | 30% | 2025 онд 1,400 тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн ЭМД хамрагдахаар төлөвлөсөн ба 2025 оны 05 сарын 27-ны өдрийн байдлаар 527 иргэн хамрагдаж 43,682,720 төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 75 хувьтай байна. | |
| | | | Хувиараа хөдөлмөр эрхлэгч ЭМД-д хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 55 | 30% | 30% | 2025 онд 3,685 хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэн ЭМД хамрагдахаар төлөвлөсөн ба 2025 оны 05 сарын 27-ны өдрийн байдлаар 1463 иргэн хамрагдаж 126,634,880 төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 79 хувьтай байна. | |
| | | | Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь | 2024 оны хамрагдалтын хувь 90 | 45% | 45% | 2025 оны 05 сарын 27-ны өдрийн байдлаар байгууллага аж ахуй нэгж 89 хувьтай байна. | |
| 2.1.2 | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | 2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан | 2 | 2 | Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, эрүүл мэндийн газарт олгохоор тооцсон гүйцэтгэлийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | | | мэдээг гарган 2 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн. | | | мэдээг 1 удаа, санхүүжилтын мэдээг 1 удаа нэгтгэн хүргүүлсэн байна. | |
| 2.1.3 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,*<br>Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | | Төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай. | Төсвийн хуваарийн дагуу | | 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар гэрээт 38 эмийн сангаас 661,857,035.00 төгрөгийн нэхэмжлэл ирүүлсэнээс 20537 хүний 661,529,500 төгрөгийн эмийн хөнгөлөлт олгохоор тооцсон байна.<br>Харин анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагад 3,504,624,532.93 төгрөгийн төсөв тавигдсанаас 2025 оны 01 дүгээр улиралд 1,764,188,694 төгрөгийн нэхэмжлэл ирүүлсэнээс 1,648,516,600 төгрөгийг олгохоор тооцсон байна.<br>Лавлагаа шатлалын улсын эмнэлэг-1, хувийн эмнэлэг-1, сувилал-1 нийт 3 ЭМБ-д 2025 оны 01 дүгээр улиралд 5,412,156,271 төгрөгийн нэхэмжлэл ирүүлсэнээс 5,137,738,312 төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон байна. Мөн ХАГГ-аас чиглэл өгсөний дагуу гүйцэтгэлийн санхүүжилтэд сарчилсан хуваарийг хийж баталгаажуулан хянаж ажиллаж байна. | 100 |
| **2.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан "Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална" зорилтын хүрээнд:** | | | | | | | | |
| 2.2.1 | *Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.2.1, БГТ-2.2.1*<br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | | -Өглөг, авлагын тоо хэмжээ<br>-Тайлан | 2024 онд 3,915,697,537 тэрбум төгрөгийн өглөг, 255,756,789 төгрөгийн авлагатай тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн. | 2 | 2 | 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар 3,915,697,537 төгрөгийн өглөгийг өгч дууссан. Авлага 255,756,789 үлдэгдэлтэй байна.<br><br>Авлагатай ЭМБ-уудтай уулзалт зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд тооцоо нийлж, төлбөрийн хуваарийг батлаж эхэллээ. | 80 |
| **3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна** | | | | | | | | |
| **3.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна" зорилтын хүрээнд:** | | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | *Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.1.2, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1* Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо<br>Гэрээний хэрэгжилтийн хувь | 2024 онд 63 гэрээт ЭМБ-ыг дүгнэсэн<br>2024 онд гэрээний хэрэгжилт 91 | 63 ЭМБ<br>90 дээш хувь | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас чиглэл өгсөний дагуу 2025 онд 63 эрүүл мэндийн байгууллагын гэрээг дүгнэж, 60 байгууллагатай гэрээг сунгаж, 3 эмийн сан гэрээгээ дуусгавар болгож, нийт гэрээний хэрэгжилт 99,4 хувьтай байна. | 100 |
| 3.1.2 | 2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо | Өрхийн эрүүл мэндийн төв-3, Сумын эрүүл мэндийн төв-14, Эмийн сан-38 | | 2025 онд Лавлагаа шатлалын 3 байгууллагатай шинэчлэн гэрээ байгуулж, 2 байгууллагын магадлан итгэмжлэл дууссан тул гэрээг үргэлжлүүлэх боломжгүй болсон.<br>Анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагатай гэрээг байгуулан баталгаажуулж, үүнээс 3 сумын эрүүл мэндийн төв хангалттгүй үнэлгээ авч зөвлөмж хүргүүлсэн. Үүнээс зөвлөмжийн хэрэгжилт ирүүлсэн 2 байгууллага байна.<br>37 эмийн сангийн гэрээг сунгаж, 2 эмийн сантай шинээр гэрээ байгуулж, нийт 60 байгууллагын гэрээг ЭМДЕГ-рт хүргүүлсэн байна. | 100 |
| 3.1.3 | Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан | Лавлагаа шатлалын гэрээт 5, анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан. | Тухай бүр | Өмнөговь аймаг дахь даатгалын хэлтэс нь Эмийн сангийн 20537, Лавлагаа шатлалын 4184 түүвэр, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 10184 анхан шатны материалд чанар төлбөрийн хяналтыг хийж ажилласан бөгөөд хяналтын журам, цахим өөрчлөлттэй холбоотой шинэчлэлийг тухай бүр и-оффис программаар түгээж, шаардлагатай бол зүүм уулзалт зохион байгуулан ажиллаж байна. Зүүм уулзалтыг 1 удаа, дотоод мэйлээр 2 удаа мэдээлэл хүргэсэн байна. | 100 |
| **3.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан “Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна” зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 3.2.1 | БГТ-3.2.1<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн | - | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэ | Нийт 219354 түүвэрт нэхэмжлэлийн хяналт хийсэн байна. | | 60 гэрээт эрүүл мэндийн байгууллагад 12-4 сарын гүйцэтгэлээр хянасан 34905 даатгуулагчийн 7,177,006,822 төгрөгийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | | н даатгуулагчийн тоо, мөнгөн дүн | | | | нэхэмжлэл хүлээн авч 7,447,784,412 төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна. | |
| 3.2.2 | БГТ-3.2.3<br><br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо | 2024 онд 2 ЭМБ-ын ажлын байранд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | 1 | 1 | 2025 онд ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний үнэлгээгээр 70-аас доош хувьтай үнэлэгдсэн 3-н СЭМТ-д зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхээр төлөвсөний дагуу ЭМДЕГ-ын даргын А/60 тушаалаар Булган сумын эрүүл мэндийн төвд томилолтоор ажиллалаа. Газар дээрх хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд зөвлөмжийг газар дээр нь өгч ажилласан ба хяналт шалгалтын дүгнэх хугацаа дуусаагүй байна. | 100 |
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | - | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2024 онд улсын байцаагчийн зөвлөмж 2 удаа боловсруулан, ЛШ 2 ЭМБ-д, АШ 17 ЭМБ 1 удаа хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилт 60 хувь. | 3 ба түүнээс дээш | 3 ба түүнээс дээш | 2024 оны гэрээ дүгнэх үйл ажиллагааны хүрээнд 70-аас доош үнэлэгдсэн 3-н сумын ЭМТ-д улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 2 байгууллагаас ирүүлсэн байна. | 80 |
| 3.2.4 | *Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.2.3, БГТ-3.2.2*<br>Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, санал үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | - | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо<br>-Хяналт шалгалтын тайлан | 2024 онд гэрээт 2 байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан. | 1 | 2 | Эрүүл мэндийн газраас ирүүлсэн албан тоотын дагуу 10-27-07/001 дугаартай удирдамжийг баталж, 2025 оны 05 сарын 02-23-ны өдрүүдэд цахим болон газар дээрх хяналт шалгалтыг хийхээр төлөвсөний дагуу хяналтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтаар зөрчил илрүүлсэн бөгөөд прокурорын байгууллагаас дугаар авч, хяналт шалгалтыг үргэлжлүүлж, хуулийн байгууллагад шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | 100 |
| **4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | | |
| **4.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан “Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө” зорилтын хүрээнд:** | | | | | | | | |
| 4.1.1 | *ЗГҮАХ-2.1.9, Байгууллагын* | - | -Авч хэрэгжүүлсэ | Аймгийн Нутгийн хишиг хөтөлбөрийн | 50 | 50 | 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний заалтад Өмнөговь | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.3* Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | | н арга хэмжээний тоо. -Тайлан | хүрээнд 10 сая төгрөг батлуулж, 2 мэргэжилтэнд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. | | | аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн байрны их засварыг тусгай заалтаар оруулсан бөгөөд төсвийг 2 сая төгрөгөөр хийлгэж, орон нутгаас 76 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлт илгээгээд байна.<br><br>Нийгмийн бодлогын хэлтсээс тус төсвийг уул уурхайн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажил эсвэл төсвийн тодотголд оруулахаар бэлдэж байна. | |
| 4.1.2 | *Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4* ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | - | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан 2 удаагийн танхимын сургалтад хамрагдсан. | Тухай бүр | | ЭМДЕГ, бусад газар, хэлтсээс зохион байгуулж буй ЭМДҮЗ-ийн тогтоолын өөрчлөлтийн 8 болон бусад сургалтад 5 удаа, тамгын газрын мэдээллийн цагт 6 удаа, цаг үеийн байдлаар зарлагдсан сургалтад тогтмол ирцтэй хамрагдаж байна. Нийт 19 сургалтад оролцсон байна. | 100 |
| 4.1.3 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-1, сургалтын тоо-2 | 2 | 2 | Даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 14 багийн сумын Засаг дарга нарт хамралтыг мэдээг хүргүүлж, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийг биелүүлж хамтран ажиллах албан тоотыг хүргүүлсэн.<br>Мөн Даланзадгад хотод байрлах ШУТИС-ийн салбар сургууль, МСҮТ-д оюутнуудыг ЭМД хамруулан, урьдчилан сэргийлэх үзлэгт оруулах албан тоотыг хүргүүлж, уулзалт зохион байгуулсан бөгөөд тус оны 9 дүгээр сард оюутны эрүүл мэнд арга хэмжээнд хамтран ажиллахаар болов. | 80 |
| 4.1.4 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 2024 онд 1500 иргэн, даатгуулагчдад мэдээ, мэдээллийг хүргэсэн. | 800 /800 | | Албан ёсны пэйж хуудсыг нээж 466 дагагчтай болгож хөгжүүлж 2025 оны 3-р сар хүртэл 10,000 гаруй хандалтыг авч ажилласан боловч 90 хоногийн хугацаа фэйсбүүкээс пост нийтлэх эрхийг хаасан байна.<br><br>Гэвч иргэн даатгуулагчид мэдээлэл өгч ажиллах үүднээс Төрийн байгууллагын зөвлөгөөнд 700 төрийн албан хаагчид, нэг-цэг, нэг үйлчилгээ арга хэмжээнүүдэд оролцож 356 иргэн нийт 1056 хүнд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, эрүүл мэндийн байгууллагаас авч болох | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээний зохицуулалт, ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тогтоол, эрт илрүүлэгийн багцын талаар мэдээлэл өгч ажиллаа. Мөн ил тодын самбарыг ажиллуулан мэдээ мэдээлэл, статистик мэдээллийг тогтмол шинэчилж ажиллаж байна. | |
| 4.1.5 | *Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.10* Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 56 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. | - | 1 | Даатгуулагч-иргэд, гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас авах сатгал ханамжийн судалгааг 3-р улиралд авч дүгнэхээр төлөвлөсөн байна. Олон нийттэй харилцах хэлтсээс зохион байгуулсан ЭМДЕГ болон орон нутгийн хэлтсүүдийг үнэлэх сэтгэл ханамжийн судалгаа болон QR уншуулах зурган мэдээллийг 60 эрүүл мэндийн байгууллагад цахимаар 2 удаа хүргүүлсэн. | 70 |
| 4.1.6 | *Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15* Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | - | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 117, шийдвэрлэлт 95 хувь. | Хагас бүтэн жилээр | | Эрүүл мэндийн даатгалын хэлтэсд 2025 оны эхний 5 сарын байдлаар 160 өргөдөл, гомдол санал ирсэн байна. Үүнээс цахим болон бичгээр 12, лавлах утсаар хандсан 112, биечлэн уулзсан 35, 11-11 утсаар ирсэн гомдол нэг ирсэн. Агуулгаар нь авч үзвэл шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар хамгийн их буюу 43 /27%/, И- баримтаар шимтгэл төлөх талаар 35 /22%/, гэрээт байгууллагын санхүүжилтын талаар 30 /19%/, эрүүл мэндийн даатгалын цахим системийн талаар 14 /9%/, бусад гэсэн асуудлаар хандсан байна. Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн цаг хугацаанд хугацаа хоцроолгүй бүрэн шийдвэрлэсэн бөгөөд талан мэдээг тамгын газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.7 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана | - | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайд 21 удаа оролцож, 12 үүрэг даалгавар ирснээс 7 тайлан хүргүүлж, үүрэг даалгаврын биелэлт 90 хувь. | Тухай бүр | | ЭМДЕГ-ын 16 удаагийн шуурхай хурал зохион байгуулагдсанаас ээлжийн амралттай холбоотой 3 шуурхай хурлын үүрэг даалгавар өгөгдөөгүй. Орон нутгийн хэлтэсд хамаарал бүхий 5 удаагийн үүрэг даалгаврын биелэлт хүргүүлсэн байна. | 70 |
| 4.1.8 | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, судалгааг хугацаанд нь үнэн зөвөөр гаргаж хүргүүлнэ. | - | Үүрэг даалгавар, судалгааны тоо | ЭМДЕГ-ын газар хэлтсээс шаардсан цаг үеийн шинжтэй 2 үүрэг даалгаварыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. | | | Үндэсний баг Өмнөговь аймагт ажиллах хугацаанд хяналт тавьж ажиллах мөн дэмжлэг үзүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын шууд үүрэг даалгавар 1 ирсэн бөгөөд үүрэг даалгаварын биелэлтийг даргад утсаар илтгэсэн ба үүрэг даалгаварын биелэлтийн хуудсад бичиж хүргүүлсэн. | 100 |
| 4.1.9 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ГТ-ний биелэлтийн хувь | Мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан. | 2 | 2 | Нэгжийн 33 арга хэмжээ, албан хаагчийн 25 арга арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, заасан хугацаанд Тамгын газрын хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах үйл ажиллагааг сар бүр дүгнэн ярилцаж, дотоод үүрэг даалгаварын биелэлтийг тооцон ажиллаж байна. | 100 |
| 4.1.10 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Архивын нэгжийн тоо (боть) | 2024 оны 10 архивын нэгжийг бүрдүүлсэн байна. | | | 2023 оны эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн - 12 боть, ирсэн бичиг-1 боть, явсан бичиг-1 боть нийт 14 боть архив үүсгэсэн ба 28 ботийг ЭМДЕГ-ын архив бичиг хэргийн албан хүлээлгэн өгсөн. 2024 оны үйл ажиллагааны архивыг үүсгэж байгаа бгөөд 2025 оны 07 дугаар сард хүргүүлэхээр төлөвлөж байна. | 100 |
| 4.1.11 | Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан | - | -Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, | - | 50 | 50 | Хос бичгээр албан бичгийг хөтлөн явуулах бэлтгэл ажлыг хангаж, компьютер бүрт монгол бичгийн фонд хэл суулгасан бөгөөд монгол бичгийн толь номыг хэлтсийн номын санд 4 ширхэгийг авч бэлдсэн байна.<br>ЭМДЕГ-аас нэгдсэн бичиг хэргийн орчуулгын программ, албан тоотын бланк хүлээгдэж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | | - Хэрэгжилтийн хувь | | | | Мөн хэлтсийн албан хаагчид ЭМДЕГ-ын монгол бичгийн сургалтаас гадна, орон нутгийн монгол бичгийн хичээлд хамрагдсан. | |
| 4.1.12 | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. | - | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо | - | Тусгай шалгуураар | | Цахим гарын үсгийг хүлээж авч бичиг хэргийн able программд оруулсан бөгөөд одоогийн байдлаар цагдаагийн байгууллагад иргэний 5 нэхэмжлэл гаргахад ашигласан байна. | 100 |
| 4.1.13 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана | - | Хэрэгжилтийн хувь | Хуулийн хугацаанд ХАСХОМ, ХАСУМ-ээ 100 хувь мэдүүлсэн байна. | 2 | - | Хэлтсийн албан хаагчид хуулийн хугацаанд ХАСХОМ өгч баталгаажуулан баталгаажуулалтын хуудсыг хүний нөөцийн албанд хүргүүлсэн. | 100 |

**ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | | |
| 5.1 | Джитал марктингийн сургалтад дахин хамрагдаж, пэйж хөгжүүлэлт, контент хийж сурна. | 3-р түвшний сертификат авсан байна. | Анхан шат | Дунд түвшин | - | 2025 оны 08 дугаар сар | - |
| 5.2 | Магистрын хөтөлбөрийг үргэлжүүлэн суралцана | Сертификат авсан байна | 1-р улирал | 2-улирал | - | 2025 оны 09 дугаар сар | - |
| 5.3 | Хууль эрх зүйн мэдлэг дээшлүүлэх сургалтад хамрагдана. | Зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдсан байна. | Прокурорын газрын зөрчлийн хэргийн талаарх сургалтад хамрагдсан. | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Авилгатай тэмцэх тухай, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон хууль хэрэглэх сургалтад хамрагдана. | Авилгатай тэмцэх газрын сургалтад 1 удаа, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны тухай холбогдох хуулийн анхаарах асуудлаар 1 удаа, Прокурорын байгууллагын хуулийн хяналтын талаар 1 удаа нийт 8 цагийн сургалтад хамрагдсан байна. | 2025 оны 3-5-р саруудад | 100 |
| 5.4 | Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг | Бие даан суралцаж | ЭМДЕГ болон орон нутгаас зохион | Компьютер дээр монгол бичгийн фондоор алдаагүй | ЭМДЕГ-аас ирүүлсэн цахим сургалтын материал болон | 2025 оны 04 -07 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ахиулах сургалтад хамрагдах | чадвараа дээшлүүлсэн байна. | байгуулсан Монгол бичгийн сургалтад хамрагдсан. | бичих, гар бичмэлийн хэвийг сайжруулах. | төрийн албан хаагч нарт зориулсан сайн дурын клубд суралцаж байна. | | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

*ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ*

*ГАЗРЫН ДАРГА* ............................ *(С.ЭНХБОЛД)*

......................... *(огноо)*

*Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

*ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ*

*ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА* ............................ *(Б.ОЮУНЦЭЦЭГ)*

2025.06.24 ......................... *(огноо)*

УЖА0067 6263305 1118156030

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

*ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН*

*ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА* ............................ *(М.БУЛГАНЧИМЭГ)*

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ӨМНӨГОВЬ АЙМАГ

.........................*(огноо)*